

Б. Лхагвасүрэн Яргуй нүдлэх цагаар

1. Эхийн агуулгад тохирох хэлц аль нь вэ?
  - A. Гүйх нохойд гүйхгүй нохой саад
  - B. Айл хүний амь нэг, саахалт хүний санаа нэг.
  - C. Долоон булчирхайгаа тоочих
  - D. Нялуунаас шулуун нялцгайгаас хатуу нь дээр
  - E. Явна явна гэсээр ямааны мах барах
  
2. Дамба даргынх зусландаа нүүхгүй удсаны учир юу вэ?
  - A. Багийн хурлын зар тараахаас эхлээд зав муутай, ажил ихтэй
  - B. Нүүлгэх ачлага уналгагүй учраас
  - C. Мөр гуайг ирж нүүлгэхийг хүлээж байсан учраас
  - D. Нүүх цаг болоогүй учраас
  - E. Гэрийн эзэн ажил амьдралаа авч явах чадваргүй, хүн бүл муутай учраас
  
3. Эхийн гол санааг хадгалсан өгүүлбэрийг олоорой.
  - A. Энэ хэдэн цадиггүй хөх ямаа яргуйнд цадах нь Дамбын хэдэн халтар хүүхэд тараг идэхээс илуу бололтой.
  - B. Яргуй нүдлэх цагийн урь орсон амгалан өдрийн наран дэргэд юм шиг ээж, Дамба даргын хэдэн бор хүүхэд хотон дотроо хурга ишгээ ноолон хөглөрнө.
  - C. Мөр өвгөн өдөр бүр сэрвийсэн хөх цохионы хэцээс Дамба даргын зуслан өөд дурандаж, дэмий л толгой сэгсэрнэ.
  - D. Хаврын цэнхэр зэрэглээнд хучуулан үлдэх говийн бор уулсаас алхам алхмаар алсарч, их нүүдлийн сүүлчийг мушгин хөдөлсөн ийм нэгэн нүүдэл Дамба даргын ухааны үүдийг нээж хөдөлсөн юм болов уу...
  - E. Дамба дарга их л ундууцангуй эхнэрийнхээ хажуугаар өтөг бууц бургиулан өнгөрч, үг дуу ч үгүй мордоод арилж өглөө.
  
4. Эхийн сэдвийг олоорой.
  - A. Хүний зан чанарын тухай
  - B. Монголчуудын нүүдэллэх ёсны тухай
  - C. Амьдралын тухай
  - D. Өрх гэрийн тэргүүний тухай
  - E. Монголчуудын зан заншил уламжлалын тухай
  
5. Дараах хэлцийн аль нь “ Өөрийнхөөрөө зөрүүдлэх ” гэсэн утгатай вэ ?
  - A. Сүнс сүлдгүй болсон.
  - B. Хий нь гарсан гүзээ шиг шалчийх
  - C. Иш мухаргүй зүтгэх
  - D. Урд хормойгоо өшиглөх
  - E. Ухааны үүдийг нээх